



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/330

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам
батлах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газрын дэргэдэх ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Ёс зүйн зөвлөлийг зохих журмын байгуулахыг Тамгын газарт, журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Ёс зүйн зөвлөлд тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2014 оны А/144 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.БИЛГҮҮН

028013493

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
2019 оны 10 дугаар сарын 3 өдрийн
11220 дугаар тушаалын хавсралт



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Төрийн албан хаагч /Төв болон орон нутгийн стандарт, хэмжил зүйн хэлтсийн ажилтан/ чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх, ёс зүйн хэм хэмжээг чандлан сахих, мөрдлөг болгох, зөрчсөн албан хаагчдад хариуцлага тооцох харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Байгууллагын ёс зүйн зөвлөл

- 2.1 Албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий ёс зүйн зөвлөл (цаашид "Ёс зүйн зөвлөл" гэх) ажиллана.
- 2.2 Ёс зүйн зөвлөлийг 5 гишүүнтэй байхаар тогтоож, албан хаагчдын саналыг үндэслэн гурван жилийн хугацаагаар томилно. Зөвлөлийн гишүүд дундаасаа удирдлагаа сонгоно. /Зөвлөлийн гишүүн ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй албан хаагч байна./
- 2.3 Ёс зүйн зөвлөл нь гомдол, мэдээллийг Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд заасны дагуу шалгаж, ирүүлсэн мэдээлэл, материалыг гишүүдийн ердийн олонхийн ирцтэй хуралдан хэлэлцэж зөрчлийн шинж байдлыг харгалзан, зөрчил гаргагчид энэ журмын 3.2-т заасан хариуцлагыг хүлээлгэх тогтоол гаргаж, зөвлөлийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 2.4 Ёс зүйн зөвлөлийн тогтоол нь аливаа нөлөөлөлд автаагүй, нотолгоонд үндэслэсэн байна.
- 2.5 Ёс зүйн зөвлөлийн хуралдаанд гомдол, мэдээллийг шалгасан албан тушаалтан болон ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчийг биечлэн оролцуулж тайлбарыг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.
- 2.6 Ёс зүйн зөвлөлийн тогтоолыг зөрчил гаргасан албан хаагчид танилцуулна.
- 2.7 Ёс зүйн зөвлөл тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад энэ тухай бичгээр хариу өгнө.
- 2.8 Ёс зүйн зөрчлийн хянан шалгах явцад цуглуулсан баримт, мэдээллийн нууцыг чандлан хадгална.
- 2.9 Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна.

- 2.10 Ёс зүйн зөвлөлийн ажилд байгууллагын удирдлага дэмжлэг үзүүлнэ.
- 2.11 Ёс зүйн зөвлөл нь Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг удирдлага болгон ажиллана.

Гурав. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

- 3.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчил гэнэ.
- 3.2 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан ёс зүйн дараахь хариуцлага хүлээлгэнэ:
 - 3.2.1 Уучлал гуйхыг үүрэг болгох;
 - 3.2.2 Сануулах;
 - 3.2.3 Хүлээлгэсэн хариуцлагыг биелүүлээгүй, дахин ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.
- 3.3 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл нь сахилгын болон захиргааны зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.
- 3.4 Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонсох ажиллагаа явуулна.

Дөрөв. Ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, мэдээлэх

- 4.1 Төрийн албан хаагч энэ журамд заасан ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг зөрчсөн нь сахилгын зөрчлийн шинжтэй болох нь тогтоогдвол дүнг байгууллагын удирдлагад танилцуулна.
- 4.2 Төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэнэ.
- 4.3 Шийтгэл ногдуулсан хугацаа дуусгавар болох хүртэл байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.
- 4.4 Жилийн эцэст тайлан гарган газрын даргад танилцуулна.